



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Нөөц бүрдүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 194 дүгээр тогтоолын 6 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 болон 6 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Төмөр зам, иргэний нисэхийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хоёр сарын хэрэгцээт шатахууны нөөцийг 2012 оны 11 дүгээр сараас эхлэн бүрдүүлэх, 2013 оноос шатахуун үйлдвэрлэгч улсуудаас өөрсдөө шууд худалдан авч хэрэгцээгээ ханган ажиллахыг “УБТЗ” ХНН-ийн даргын үүргийг гүйцэтгэгч Г.Сэрээнэндорж, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга С.Батмөнх, “МИАТ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Орхон нарт тус тус даалгасугай.

2.Шатахууны нөөц бүрдүүлэх, цаашид шатахуун үйлдвэрлэгч улсуудаас өөрсдөө шууд худалдан авах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сайдын зөвлөх /Ж.Бямбацогт/-д үүрэг болгосугай.



А.ГАНСҮХ